

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн нэр	3
1.2. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байршил	3
1.3. Төслийн хүчин чадал	3
1.4. Химийн бодисын агуулах	4
1.5. Төслийн дэд бүтэцийн байдал	4
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
2.1. Төсөл хэрэгжиж буй газрын өнөөгийн байдал	6
2.2. Төсөл хэрэгжих орчны уур амьсгал	6
2.3. Төсөл хэрэгжих орчны хөрсөн бүрхэвч, түүний онцлог	7
2.4. Төсөл хэрэгжих орчны газрын гадарга, хэвлийн тогтоц онцлог	8
2.5. Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг	9
2.6. Төсөл хэрэгжих орчны гадаргын усны судалгаа	9
2.7. Газрын доорх ус буюу гидрогеологийн нөхцөл	10
2.8. Төсөл хэрэгжиж орчны амьтны аймаг, бүрэлдэхүүн	11
2.9. Төсөл хэрэгжих орчны нийгэм, эдийн засгийн хөгжил	12
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	13
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	16
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
4.2. Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө	20
4.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	20
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	20
4.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	20
4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний арга хэмжээний зардал	22
4.8. Бомт-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	23
4.9. Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх хуваарь	23
4.10. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ	24
4.1. Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	24
Хавсралт материалууд	27

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Одон кашмер” ХХК

1.2. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байршил: Уг химийн бодисын агуулах нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хороо, туулын 1-4 тоот түрээсийн байранд байрлана. Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газрын байршлын координатыг хүснэгт 1-д, төсөл хэрэгжих орчны тойм зураг болон талбайн харагдах байдлыг зураг 1,2-д харуулав.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих газрын байршлын координат

№	X	Y	Цэгүүд
1.	106°42'20,5"	47°53'57,3"	1-2
2.	106°42'20,07"	47°53'58,47"	2-3
3.	106°42'23,58"	47°53'58,65"	3-4
4.	106°42'23,89"	47°53'57,64"	4-1



Зураг 1. Байршлын тойм зураг

1.3. Төслийн хүчин чадал

“Одон кашмер” ХХК нь хонь болон тэмээний ноосон утсыг БНХАУ-с импортлон оруулж ирж худалдаалах үйл ажиллагаа явуулдаг бөгөөд компанихаа үйл ажиллагааг өргөжүүлэн ноосон утсыг боловсруулан бэлэн болгосон дараа угааж, зөөлрүүлэх зориулалт бүхий 2 төрлийн химийн бодисыг импортлон оруулж ирж худалдаалаахаар төлөвлөж “Алтан дов” ХХК-ний Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32-р хороо, туулын 1-4 тоотод байрлах 80м² талбайтай агуулахын зориулалт бүхий өрөөг түрээслэн үйл ажиллагаагаа явуулж байна. Химийн бодсын нэр төрөл, жилд оруулж ирэх хэмжээг доорхи хүснэгтэд оруулав.

Хүснэгт 2.

№	Монгол нэр	Олон улсын нэр	CAS дугаар	Жилд оруулж ирэх хэмжээ, кг
1.	Зөөлрүүлэгч	Poly /dimethylsiloxane/	63148-62-9	500
2.	Саван	Cocoamidopropyl betian	61789-40-0	500

Уг бодисууд нь 20 литрийн багтаамжтай хуванцар саванцар саванд савалгаатай байдаг ба саван болон зөөлрүүлэгч бодис нь хүйтэнд тэсвэр муутай, хөлдсөн тохиолдолд ашиглаж болохгүй учир зөвхөн дулааны улиралд оруулж ирэхээр төлөвлөсөн.

“Хуашинг трэйд” ХХК-тай хийсэн ELHX2022/1116 тоот гэрээний дагуу савангаас 2026 онд 500 кг, зөөлрүүлэгчээс 500 кг, нийт 1000 кг-г импортлон оруулж ирэхээр төлөвлөсөн байна. Химийн бодисууд нь шингэн төлөвтэй бөгөөд өнгөгүйгээс шар өнгө хүртэл, тунгалаг эсвэл бага зэрэг булиргартай байдаг. Бэлэн бүтээгдэхүүн болсон ноосон хувцасыг эхлээд савангаар угааж, дараа нь зөөлрүүлэгчид хийж дэвтээж хүн өмсөхөд хатгахгүй, зөөлөн тухтай байдал үүсгэхэд зориулсан бодис байна.

Хүснэгт 3. 2026 онд импортлон оруулж ирэх, ашиглах химийн бодисын хэмжээ, кг

№	Монгол нэр	Олон улсын нэр	CAS дугаар	Жилд оруулж ирэх хэмжээ, тн
1.	Зөөлрүүлэгч	Poly /dimethylsiloxane/	63148-62-9	0,5
2.	Саван	Cocoamidopropyl betian	61789-40-0	0,5
Нийт дүн				1.0

1.4. Химийн бодисын агуулах

Химийн бодисын агуулах нь Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32-р хороо, туулын 4-1 тоот 80 м² түрээсийн байранд байрлана. Уг агуулахыг дээрхи 2 төрлийн химийн бодисыг хадгалах зориулалтаар тохижуулан, агуулахад Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын галын аюулгүй байдлын дүгнэлт болон нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас агуулахын дүгнэлтийг тус тус авсан байна.



Зураг 2. Химийн бодисын агуулах

1.5. Төслийн дэд бүтэцийн байдал

Дулаан хангамж: Тус агуулах нь “Алтан дов” ХХК-ний түрээсийн байранд байрладаг бөгөөд уг барилгын дулаан хангамжийг цахилгаан зуух ашиглан халаалтын асуудлаа шийдсэн байна.

Бохир усны шийдэл: Тус барилга нь сантехникийн холболтонд бүрэн холбогдсон бөгөөд, үйл ажиллагаанаас үүсэх ахуйн бохир усыг өөрийн 5м³ багтаамж бүхий бохирын цооногт хуримтлуулан дүүргэлтээр нь бохир ус соруулж тээвэрлэх гэрээний дагуу зохих төлбөрийг төлж зайлуулдаг байна. Ариун цэврийн өрөөний фото зургийг доор оруулав.



Зураг 3. Ариун цэврийн өрөө

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төсөл хэрэгжиж буй газрын өнөөгийн байдал

Судалгаанд хамрагдаж буй газар нь далайн түвшинээс дээш 1254 метр өргөгдсөн, тэгшивтэр талбайд байрлана. Уг газар нь хотын төвөөс зайдуу, ойр орчинд суурьшлын бүс харьцангуй бага агуулахын баруун талд “Монгол фермер” ХХК-ийн хөргүүртэй агуулах, зүүн талд авто зогсоол, сэлбэг худалдаа эрхэлдэг аж ахуй нэгжүүд үйл ажиллагаа явуулдаг байна. Агуулахын газар нь машин техникийн механик хөдөлгөөн болон хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хөрс, ургамлан нөмрөг элэгдэл, талхлагдалтад өрсөн байна. Агуулахын газрын өнөөгийн төрхийг зураг 5-д үзүүлэв.



Зураг 4. Агуулахын газрын өнөөгийн байдал

2.2. Төсөл хэрэгжих орчны уур амьсгал

Төсөл хэрэгжиж буй газар нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р дүүргийн нутаг дэвсгэрт байрлана. Улаанбаатар хот нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай, Хэнтийн уулархаг их мужийн хэсэгт, тухайлбал Хэнтийн уулархаг баруун өмнөд шувтрага үзүүрт Туул голын өргөн хөндий, ай сав цутгал голуудын бэлчирт байрладаг, далайн төвшнөөс дээш 1350 метр өндөрт Номхон далайгаас 1600 орчим км алсад, Дэлхийн экватороос хойш 5310 км, хойд туйлаас урагш 4690 км зайтай буюу дэлхийн хойд өргөрөгийн $47^{\circ}55'$, зүүн уртрагийн $106^{\circ}55'$ -ын солбилцолд оршдог. Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай. Өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -49°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 38.6°C , үнэмлэхүй их бага температурын агууриг нь 87.6°C болдог энэ эрс тэс ялгаатай бөгөөд ийм их зөрөө дэлхийн аль ч улсын нийслэлд гардаггүй байна. Жилийн дундаж температур нь -3°C , хамгийн хүйтэн 1-р сарын температур нь -26°C байх бөгөөд -30°C -аас бууж хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим байна.

Улаанбаатарт хүйтрэлтгүй үргэлжлэх хугацаа 5-р сарын 29-ны орчмоос 9-р сарын 2 орчим хүртэл буюу 90 хоног байна. Энэ хугацаанд агаарын температур 0°C -аас доош буухгүй. Жилийн хамгийн дулаан сар нь 7-р сар бөгөөд дундаж температур нь 17°C ,

хамгийн халуун болсон нь 38⁰С хүрсэн. Зундаа 30⁰С-аас давж халуун болох өдрийн тоо 10 орчим, ган болох магадлал 30 орчим хувь байдаг. Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн цэлмэг хөх тэнгэрт хотуудын нэг бөгөөд жилдээ 250-иад хоног цэлмэг байдаг. Улаанбаатар хот манай орны салхи багатай газрын тоонд орно. Жилдээ салхигүй өдөр 100 орчим байх бөгөөд салхины хурд 4-6 м/с, баруун хойд зүгийн салхи голлоно. Өвөл салхи багатай, хавар нь салхи ихтэй. Монгол орны уур амьсгалын мужлалын хувьд авч үзвэл Улаанбаатар хот нь хуурайдуу сэрүүн зунтай хахир өвөлтэй нутагт багтана. Улаанбаатарт жилд дунджаар 233 мм тунадас унаж, ууршилт нь 648 мм болдог. Чийгшлийн байдал 0.36 байдаг. Агаарын харьцангуй чийг 1-р сард 70 орчим хувь, 7-р сард 60 орчим хувь байдаг.

2.3. Төсөл хэрэгжих орчны хөрсөн бүрхэвч, түүний онцлог

Улаанбаатар хот орчмын хөрс нь хөрс-газар зүйн мужлалтаараа Хангайн их муж, Хэнтийн мужийн Хэнтийн захын хэсгийн тойрогт хамрагдах бөгөөд уулын ба хээрийн хар хүрэн, сайргархаг хар хүрэн хэв шинжит хөрс зонхилон тархана.




Зураг 5. Улаанбаатар хотын хөрсөн бүрхэвч, төрлөөр

Эдгээр хөрс нь уулархаг хэсэгтээ элюви ба элюви-делювийн хурдас, тэдгээрийн бэл хормойгоор делюви ба элювийн, голын сав хөндийгөөр аллювийн хурдсууд дээр тогтжээ. Элюви, делюви, элюви-делювийн хурдас нь голдуу дунд ба хөнгөн шавранцар, элсэнцэр ширхэгийн бүрэлдэхүүнтэй байхад, аллювийн хурдас нь дунд ба хүнд шавранцараас шаварлаг бүрэлдэхүүнтэй байна. Улаанбаатар хотын хөрсөн бүрхэвч ерөнхийдөө элэгдэл эвдрэлд орсон, ургамалан бүрхэвч талхагдсан, хог хаягдал их хэмжээгээр хуримтагдсан байдал ажиглагдаж байна. Улаанбаатар хотод хөнгөн үйлдвэрлэл болон цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл төвлөрсөн, бага оврын уурын зуух ба ердийн галлагаат зуух, автомашины тоо эрс нэмэгдэж байгаа зэрэг нь хотын хөрсний бохирдлын голлох эх үүсвэр болж байна. Улаанбаатар хотын бүсэд тархсан хөрсүүд багавтар ялзмагтай, хөнгөн механик бүрэлдэхүүнтэй байдаг тул бохирдуулагч бодисууд хөрсний өнгөн давхаргаас доош шилжих латерал хөдөлгөөн эрчимтэй байх ба энэ нь Туул ба жижиг голуудын хөндийн хөрс, хурдсанд илүүтэй хурдацтай байна. Улаанбаатар хотын хөрсөн бүрхэвч маш Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, 2026 он

хүчтэй элэгдэл эвдрэлд орсон, ургамалан бүрхэвч талхагдсан, хог хаягдал их хэмжээгээр хуримтагдсан байдал ажиглагдаж байна. Ихэнх газруудад хөрсөн бүрхэвч үндсэндээ алга болж эх чулуулаг ил гарсан байна. Улаанбаатар хотод хөнгөн болон цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл төвлөрсөн, бага оврын уурын зуух ба ердийн галлагаат зуух, автомашины тоо эрс нэмэгдэж байгаа зэрэг нь хотын хөрсний бохирдлын голлох эх үүсвэр болж байна. Хотын цахилгаан станцууд, аж үйлдвэрийн томоохон үйлдвэрүүд, тэдэнтэй холбогдсон бохир ба хаягдал усны сурвалжууд, хог хаягдлын төв цэгүүд нь хот орчмын салхины голлох чиглэлийн эхэн болох баруун, баруун хойт, хойт хэсэгт байрласан байдаг учраас хотын баруун, төв ба хойд хэсэг, дархан цаазат Богд уулын ар хажуугийн экосистемд сөрөг нөлөө үзүүлэх нөхцлийг бүрдүүлдэг. Улаанбаатар хотын бүсэд тархсан хөрсүүд багавтар ялзмагтай, хөнгөн механик бүрэлдэхүүнтэй байдаг тул бохирдуулагч бодисууд хөрсний өнгөн давхаргаас доош шилжих латерал хөдөлгөөн эрчимтэй байх ба энэ нь Туул ба жижиг голуудын хөндийн хөрс, хурдсанд илүүтэй хурдацтай. Улаанбаатар хотын хөрс-литогеохимийн ерөнхий бохирдолтын түвшин Улаанчулуут, Дарь-эхийн хогийн цэг, Хотын цэвэрлэх байгууламж, Нарантуул зах, Шархадны автомашины зах, III-IV цахилгаан станц, Дэнжийн мянга, Хайлаастын ам, Шарга морьтын зуслангийн адаг, 100 айл орчим зэрэг газруудад онцгой их буюу хотын дундаж агууламжаас 10-16 дахин их байж, “хэт их бохирдолттой” зэрэглэлд багтана. Хотын төв хэсэг, гэр хороолол, баруун талын дүүргийн нутаг дэвсгэр нь бүхэлдээ хотын дундаж дэвсгэр агууламжаас 3-8 дахин ($Z_c = 3.0 - 8.0$) их буюу “бохирдолттой” гэсэн зэрэглэлд багтаж байна.

2.4. Төсөл хэрэгжих орчны газрын гадарга, хэвлийн тогтоц онцлог

Улаанбаатар хот түүний орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн дэнжийн хэсэгт байрладаг. Газарзүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд багтдаг бөгөөд 1950-2268 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг өндөр уулсаар хүрээлэгдэнэ. Богдхан уул нь зүүнээс баруун тийш чиглэсэн 40 орчим км үргэлжилсэн нуруу юм. Хамгийн өндөр оргил нь далайн түвшинээс дээш 2268 м өндөрт орших Цэцээ гүн юм. Төсөл хэрэгжиж буй газрын байршлыг доорхи зурагт харуулав.



Зураг 6. Төслийн байршлын зураг /Google map/

2.5. Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг


Нийслэл хот нь А.А.Юнатовын (1950) ургамал газар зүйн мужлалаар Монгол дагуур, Монголын хээрийн мужийн Баруун Хэнтийн тойрог, И.А.Коротковын (1978) ойн ургамлын мужлалаар Хэнтий-Сүх голын мужид тус тус хамаарна. Ургамлын хэв шинжийн хувьд уулын хээрийн ургамалшилт уулсын задгай энгэрт голлоно. Ургамлын тархалт өндрийн бүсжилтийн зүй тогтолд захирагдана.

Энэ тойрог нийт нутгийн 6,62% -г эзэлдэг. Одоогийн байдлаар энэ тойрогт 946 зүйл ургамал бүртгэгдсэний 115 зүйл модлог, сөөглөг ургамал байна. Монгол-Дагуурын тойргийн ургамлыг экологийн бүлгүүдээр нь ангилж үзвэл чийгсэг 234, чийгсүү-хуурайсаг 134 зүйл, чийгсүү-намагсаг 76 зүйл, намагсаг 70 зүйл, хуурайсуу-намагсаг 9 зүйл, уссаг 26 зүйл, хүйтсэг бүлгийн бүх ургамал 73 зүйл чулуусаг бүх бүлгийн ургамал 145 зүйл, давссаг бүлгийн ургамал 65 зүйл, элссэг ургамал 20 зүйл байна.

2.6. Төсөл хэрэгжих орчны гадаргын усны судалгаа

Туул гол нь бусад газрын нэгэн адил сүүлийн жилүүдэд тохиолдож буй уур амьсгалын өөрчлөлт, дулаарал, хүний үйл ажиллагаа зэрэг хүчин зүйлс нь тодорхой хэмжээнд сөргөөр нөлөөлж усны нөөц багасаж гол бохирдож байгаа мэдээ бий [Гадаргын усны тооллого 2005, Геоэкологийн хүрээлэнгийн бүтээл 2005-2013]. Туул гол нь Хан Хэнтийн нурууны Бага Хэнтий далайн түвшнээс дээш 2000 м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдгийн өврийн салбар уулсаас эх авах Номин гол, Шороотын даваа /1918 м/-ны өвөр, Шар булгийн сарьдаг /2542 м/-ийн салбар уулсаас эх авах Шороотын давааны өврөөс гарах Нэргүй голын бэлчрээс Туул хэмээн нэрлэгдэнэ. [Даваа Г.2015]. Туул гол Орхон голд цутгах хүртлээ урт нь 871 км, 6-р эрэмбийн гол ажээ. Туул голд Хэнтийн нуруу, түүний салбар уулсаас эх авсан Галтгай, Хийд, Хаг, Хонгор, Баруун, Зүүн Баян, Заан, Тэрэлж, Хөл, Улиастай, Сэлбэ Бөхөг, Түргэний зэрэг олон голууд цутгаж усан сүлжээг үүсгэнэ.

Туул голын хөндий Улаанбаатар хотоос доош тавиурч урсацын алдагдал ихэснэ. Туул голын жилийн дундаж өнгөрөлт Улаанбаатар орчим 26.6, Сонгинод 25.8, Өндөр ширээтэд 24.1 шоо м/с байгаа нь дээрх дүгнэлтийг баталж байна. Голын ус хурах талбай 48868.4 ам.км байна. Туул гол усны горимын хэв шинжээрээ хаврын шар усны болон зуны хур борооны үерийн горимтой голд хамрагддаг. Голын урсацыг бүрдүүлэгч үндсэн хүчин зүйл нь зун намрын хур бороо учраас усны түвшин дулааны улиралд ихээхэн тогтворгүй байдаг. ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн /хуучин нэрээр/-гийн судлаачид сүүлийн арваад жилийн хугацаанд Туул голын судалгааг иж бүрнээр нь хийж байна. Түүнчлэн Япон Улсын Киотогийн Их сургуулийн Экологийн судалгааны төвийн эрдэмтэд, судлаачидтай хамтран 2006 онд Туул голын уртын дагуу 19 цэгт хэмжилт судалгаа хийсний гадна сүүлийн 5 жилийн хугацаанд Туул голын цэвэр цэг болох Туул-Тэрэлжийн гүүр, бохир цэг болох Туул-Сонгины гүүр орчмоос сар бүр дээж авч судалгаа шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Энэхүү хамтарсан судалгаагаар Туул голд Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдэн гарсан бохир ус нийлснээс доош нийт азотын агууламж нэмэгдэж үүний дотор уусаагүй суспензлэгдсэн органик азотын агууламж эрс нэмэгдсэнийг тогтоосон байдаг. Түүнчлэн нийт фосфорын хэмжээ мөн энэ хэсгээс эхлэн нэмэгдэж, түүний дотор ууссан органик биш фосфор /УОБФ/ давамгайлж байсан бол урсгалын дагуу нийт фосфорын хэмжээ аажим буурч, үүний зэрэгцээ УОБФ суспензлэгдсэн фосфорт шилжих хандлага ажиглагдаж байгааг тогтоогоод байна.




Зураг 7. Туул голын уртын дагуух нийт азотын агууламжийн өөрчлөлт

Голын усны цахилгаан дамжуулах чанар /ЕС/ Улаанбаатараас дээш хэсэг Туул-Тэрэлж /M05/-д 42-61 µS/cm –ийн хооронд хэлбэлзэж маш бага утгатай байсан бол хотоос доош Туул-Сонгино /M08/-д 144-374 µS/cm болж эрс өссөн байна. Түүнчлэн усны дундаж температур аль ч тохиолдолд бохир цэгт илүү байна.



Зураг 8. Туул гол Сонгины гүүр, 2010.05



Зураг 9. Туул-Сонгино /M08/ усны нийт фосфорын агууламжийн өөрчлөлт

Зургаас харахад Туул гол Сонгино орчимд голын усны нийт азотын тухайн жилийн дундаж агууламж 150-450 µM, нийт фосфорынх 5.3-33 µM-ийн хооронд хэлбэлзэж цэвэр цэгтэй харьцуулахад маш их бохирдолттой байгаа нь харагдаж байна.

2.7. Газрын доорх ус буюу гидрогеологийн нөхцөл

Гидрогеологийн нөхцөлийн хувьд Туул голын хөндийн аллювийн гаралтай орчин үеийн (all. Q дөрөвдөгч) сэвсгэр хурдсан дахь уст үе давхаргад хамаарагдана. Уг сэвсгэр хурдасны бүрэлдэхүүнд голын мөлгөр бөөрөнхий хайр, хайрганцар, жижиг бул чулуу давамгайлсан байх бөгөөд харин элсэнцэрийн багавтар хольц ажиглагддаг.

Туул голын хөндийн аллювийн сэвсгэр хурдас доторхи ул хөрсний усны түвшний горимд агаарын хур тунадасны унасан хэмжээ шууд нөлөөлж усны түвшний хамгийн их дээшлэлт нь 7, 8, 9-р саруудад явагддаг бөгөөд оргил үе нь 8-р сард 0.53 м-1.2 м-т дээшлэж хур тунадасны хамгийн их уналтай шууд давхцаж байгаа нь усны нөөц нь нэг талаас хур тунадасны усаар тэжээгддэг байна. Харин тэжээлийн гачиг үед 1, 2, 3, 4-р саруудад ул хөрсний усны түвшин 6.5-13.7 метрээр огцом унадаг. Энэ нь гадаргуугийн ус, хөрс хөлдөж тэжээгдэлгүй болсонтой холбоотой. Хавар, зуны улиралд газрын доорхи усны түвшин дээшлэхэд тэжээгдэл эрс нэмэгдэн газрын доорхи усны түвшний хамгийн өндөр хэмжээ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, 2026 он

гол үерлэж татмын ихэнхи талбайг эзэлдэг 7,8-р сард ажиглагдах ба өвөл гол хөлдөхөд газрын доорхи усны тэжээгдэл багасах боловч газрын доорхи усны урсац үргэлжлэн явагддаг зүй тогтолтой. Туул голын ай савын аллювийн гарал үүсэлтэй хайрга, хайрганцар, хурдас нь нэг талаасаа сайтар угаагдан мөлгөржсөн учраас усанд амархан уусдаггүй эрдэс бодис нь үлдсэн ба нөгөө талаас, натрийн хээрийн жонш, кварцаас бүрэлдэн тогтсон учраас газрын доорхи усны химийн найрлагад нь онцгой нөлөө үзүүлдэггүй, цэнгэг зөөлөн, ихэвчлэн гидрокарбонат, натри кальци мөн хлорт кальци зонхилсон зөөлөвтөр, цэнгэг ус байна. Туул голын хөндийн аллювийн хурдас дахь газар доорхи ус нь Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн цорын ганц эх үүсвэр юм.

2.8. Төсөл хэрэгжиж орчны амьтны аймаг, бүрэлдэхүүн

Судалгаа хийж буй газар нь хүн амын төвлөрөл ихтэй, хотын төвд байрлах тул энд ан, амьтан гэх зүйл байхгүй байна. Харин Нийслэлийн ногоон бүсийн амьтадын талаархи мэдээллийг доор оруулав. Нийслэлийн ногоон бүсийн нутаг дэвсгэр нь амьтны аймгийн газарзүйн мужлалтаараа Умардын их мужийн хөвч тайгын дэд мужийн Хэнтийн тойрогт багтана. Судлаачдын тооцоолсноор Нийслэлийн ногоон бүс нутагт 50 орчим зүйл хөхтөн амьтад тэмдэглэгджээ. Эдгээрээс буга, бор гөрөөс, зэрлэг гахай, хүдэр, янгир зэрэг туурайтан амьтад ногоон бүсийн шилмүүст болон холимог ойд амьдардаг боловч их хотын чимээ шуугиан хүн, авто хөсөг, бэлчээр тэжээлийн хүрэлцээ зэргээс шалтгаалан нэг газар байнга оршин амьдардаггүй улирлын чанартай шилжин нүүдлэдэг онцлогтой.

Харин ойн зах, хад асгат уулсын ам хөндийгөөр чоно, үнэг, хярс зэрэг махан идэштэн, чандгана, туулай, дагуур огдой зэрэг туулай хэлбэртэн амьдардаг. Түүнчлэн хуш голлосон шилмүүст ойд хэрэм, жирх, ойн хормойгоос эхлэн бүх ам, хөндийгөөр тарвага, урт сүүлт зурам, оготно, үхэр огдой зэрэг амьтад бүсийн хэмжээнд элбэг тархжээ. Жигүүртний хувьд энд нэлээд олон зүйлийн шувуу тэмдэглэгдсэн бөгөөд уулын ар өврийн холимог ой, ам хөндийд хур, сойр, ятуу, хөтүү, ятга шаазгай, бялзуухай, болжмор, хөх бух, хараацай, хөх цэгций, хад цохиогоор хон хэрээ харцага, бүргэд, начин шонхор зэрэг шувууд байна.

Эдгээр олон зүйлийн шувууд нь ургамлын үр үндэс, хорхой шавьж, амьтны сэг сэлтийг идэж жилийн турш амьдарна. Нүүдлийн шувуу ирэх үеэр шувууны зүйлийн тоо хэд дахин нэмэгддэг байсан. Сүүлийн жилүүдэд гадны элдэв нөлөөллөөс болж шувуудын үүрлэн өндөглөх, үр төлөө бойжуулах, нуугдан хоргодох, нүүдлийн үедээ байршин амьдрах тохиромжтой тайван нутаг нь багасан, амьдралын хэвийн зохицол алдагдах болсноос, нүүдлийн шувуудын ирэх тоо эрс цөөрөх болжээ.

Шувуудын дотор тагтааныхны Columbidae голдуу агнуурын ач холбогдолтойд тооцогдоно. Хэнтий нурууны захын нам уулсаар хадны тагтаа- *Columba rupes trik*, дагуур ятуу- *Perdix daurica*, тоодог- *Otis tarda*, ногтруу- *Syrhaptes paradoxus* зэрэг суурин цөөн зүйл байдаг. Нугасныхны Anatidae бор галуу- *Anser anser*, бор нугас- *Anas strepera* зэрэг нүүдлийн усны арав гаруй зүйл бий.

Агнуурын хөхтөн амьтан Улаанбаатар, Төв аймгийн хэмжээнд агнуурын 34 (46,5%) зүйл байдгаас 22 зүйл нь агнуурын “үндсэн” буюу одоо мөрдөж байгаа Монгол улсын ан агнуурын хуулийн дагуу агнан ашиглаж болох ердийн ан юм. Үнэт үндсэн чухал ан болох цагаан зээр, монгол тарваганы тархац нутаг хомсдоноос Монгол улсын нэгдэн орсон олон улсын конвенци, эрх зүйн бусад акт, баримтын дагуу агнуураас албан ёсоор чөлөөлөгджээ. Харин урьд агнуурын ач холбогдол багатай, тохиолдлоор шахам агнадаг байсан агнуурын шууд ашиг өгөөж, зах зээлийн үнэ цэнэ багатай, хүч хөдөлмөр илүү зарцуулдаг ч байгалийн орчин зүйн (экологийн) тэнцвэрт байдал, хөгжилд чухал

оролцоотой зурам, маануул мий, халздай дорго зэрэг бага тархацтай цөөн амьтад зарим талаар үндсэн ан болж болзошгүй тал ажиглагдаж байна. Амьтдын дотор монгол тарваганы нөөц эрс багасаж, байгалийн орчны тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлөх хэмжээнд очсон байна. Хотын ногоон бүсэд амьдрах амьтад нь нилээд онцлогтой. Учир нь хөл хөдөлгөөн ихтэй их хотын дэргэд орших тул байнга дайжин нүүдэллэж байдаг. Тухайлбал сүүлийн зуугаад жилд Богдхан уулнаас хандгай, хүрэн баавгай, нохой зээх, сохор номин, бэлээр нь байсан цагаан зээр дайжин оджээ.

Шавьж: Богдхан уулын дархан цаазат газарт 16 баг 174 овгийн 1660 зүйл шавьж амьдардаг. Үүнээс 6 зүйл шавьж 2008 оны Богдхан уулын улаан номонд орсон байдаг. Энэ 6 зүйлд Апполлон эрвээхэй Parnassius Apollo, Ксут дэвүүрээхэй Sinoprinceps xuthus, Махаон эрвээхэй Papilio machaon, Инжирийн шумбуур Deilephila elpenor, Бэр цэцэгч шумбуур Nemapis tityus, Модестус үхэр хэдгэнэ Bombus modestus зэрэг зүйлүүд орсон байдаг.

2.9. Төсөл хэрэгжих орчны нийгэм, эдийн засгийн хөгжил

Газар нутаг: Сонгинохайрхан дүүрэг 1992 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр Сонгино нэртэй байгуулагдаж, улмаар 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 39 тоот "Дүүргийн нэрийг өөрчлөх тухай" тогтоолоор Сонгинохайрхан дүүрэг болгон өөрчилжээ. Тус дүүрэг нь 120,6 мянган га газар нутагтай, нийслэлийн баруун жигүүрт Баянгол, Хан-Уул дүүрэг, Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Борнуур, Батсүмбэр зэрэг сумдтай хил залган оршино. Нийслэлийн хэмжээнд мал аж ахуй эрхлэх бүсийг тогтоохдоо Сонгинохайрхан дүүргийн 20, 21 дүгээр хороо буюу хориглох бүсийн хилийн зурвасыг Баруунтуруун, Тахилт, Шижир, Толгойт, Гүнт, Хужирт, Хадлан, Халзан, Мухартын даваа, Өвөрхангайн Хархорин, Сэлэнгийн Алтанбулаг чиглэлийн засмал замын уулзвараар тогтоосон байна. Эрчимжсэн мал аж ахуйг Жаргалант тосгонд хөгжүүлэх боломжтой бөгөөд энэ бүс нутаг нь хээрийн ерөнхий шинж төрхийг хадгалсан, чийглэг сэрүүн, ой нуга хээр хосолсон усан хангамж сайтай, бэлчээр элбэгтэй нутаг.

Газарзүй байршил: Нийслэл хотынхоо баруун өмнө талд сүндэрлэх тахилга сүлдэт уул нь хад асгатай хайлаас харгана ихтэй, агь, ганга, цагаан төмс, гандигарын мод зэрэг эмийн ургамал ургадаг, галт хар үнэгтэй учир өвөл цасгүй өвөлждөг гэсэн домог бий. Сонгинохайрхан уулын эзэн хөх үхэр унаж, араа соёо нь зөрсөн хөх өвгөн аугаа их эдийн засгийг баригч, хамгийг эрх мэдэлдээ хураагч, сайтар гялалзан харагдагч, үзэсгэлэнт Өндөрхайрханы өмнөх догшин хар үүлийн дунд сүрхий хилэнт бараан нүүртэй, гартаа улаан торгон молцогтой зэвсэг сэлэм, эрээн мод барьсан хөх өвгөний дүрийг дүүргийн сүлдэнд залжээ. Дүүргийн туг нь улаан хүрэн өнгөтэй торгон дээр сүлдийг өнгөөр ялгаж дүрслэдэг ба сүлд тэмдгийг туган дээр ямагт босоо байрлуулдаг уламжлалтай.

Хүн ам, айл, өрх: Тус дүүрэг нь хөдөөгөөс хот руу шилжин ирэгсдээр бүл нэмсээр өдгөө 65423 өрхийн 261917 иргэнтэй өнөр дүүрэг болжээ. Дүүргийн 32 хорооны нийт өрхийн 17721 нь буюу 27 хувь нь байшин хороололд амьдардаг.

Хөдөө аж ахуй: Мал тооллогын дүнгээр мал бүхий 20 хорооны 1379 өрхийн, 10 аж ахуйн нэгж байгууллагын нийт 62654 толгой мал тоологдсон байна.

ААН: Дүүргийн нутаг дэвсгэрт улсын хэмжээнд танигдсан олон үйлдвэр аж ахуйн нэгж бий. Тухайлбал, “Талх чихэр”, “Алтан тариа”, “Монсүү”, “Ган хийц”, “Шилэн хийц”, “Хүнс трейд”, “Мах импекс”, “Жем интернэшнл”, “Саван трейд”, “Ган хийц”, “Сүлжээ” ХК зэрэг томоохон аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр үйлдвэрүүд нийслэлийн нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 10 гаруй хувийг эзэлж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уг төслийн хувьд химийн бодис импортлох, химийн бодисын тээвэрлэлт, химийн бодис түр хадгалах зэрэг үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг нөлөөлөл нь байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хэрхэн сөрөг нөлөөлөл үзүүлэхийг Леопольдын матрицын арга, магадлан жагсаах арга зэргийг ашиглан тодорхойлов.

Хүснэгт 3. Төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн матриц

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөлөлд өртөгчид, балл					Нийт дүн
		Агаарын чанар	Усан орчин	Хөрсөн бүрхэвч	Ургамлан нөмрөг	Амьтаны аймаг	
1.	Химийн бодисыг хүлээн авах, буулгах	3 LT	1 ST	2 LT	1 ST	1* LT	8
2.	Химийн бодисын тээвэрлэлт	2 ST	1 ST	2 LT	1 ST	1* LT	7
3.	Химийн бодисын түр хадгалалт, борлуулалт	3 LT	1* LT	1* LT	1* ST	1* LT	7
4.	Химийн бодисын сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдал	3* LT	2* LT	2* LT	1* ST	1* LT	9
5.	Бусад хүчин зүйл	1 LT	1* LT	1 LT	1* ST	1* LT	5

Тайлбар:

1. Матрицын нүдэнд нөлөөллийн эрчмээс хамааруулан 0, 1-5 онооноос оногдох болно.
2. ST – богино хугацааны нөлөөлөл
3. LT – урт хугацааны нөлөөлөл
4. * - урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанаас нөлөөллийн хэмжээ хамаарна.

Дээрхи хүснэгтээс харахад хамгийн их нөлөөлөх хүчин зүйлс нь химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт болон химийн бодисын сав баглаа боодлоос үүсэх хог хаягдал зэрэг нь тодорхой хэмжээний сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. БНХАУ-аас импортлон оруулж ирэх 2 төрлийн химийн бодис нь ноосон утсыг боловсруулан бэлэн болгосон дараа угааж, зөөлрүүлэх зориулалт бүхий бодис учир байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хувьд харьцангуй бага байхаар байна.

Төслийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй химийн бодисын сав, баглаа боодол хаягдлыг мэргэжлийн байгууллага болох “Элемент” ХХК-тай хийсэн “Химийн хорт болон аюултай хаягдал тээвэрлэх, устгах” гэрээний дагуу өгч шилжүүлэхээр төсөлд тусгасан байна.

Химийн бодисын агуулахын зүгээс байгаль орчинд учирч болзошгүй эрсдлийн үнэлгээг матрицийн аргаар үнэлэн доорхи хүснэгтэд оруулав.

Хүснэгт 4. Байгаль орчинд учирч болзошгүй эрсдлийн үнэлгээний матриц

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эрчим цар хүрээ	Нөлөөллийн эрчим			
			Бага	Дунд	Их	Онцгой их
1.	Гал түймэр	Зайлшгүй болох				
		Магад болох				
		Болзошгүй		+		
		Магад болохгүй				
		Болохгүй				
2.	Химийн бодис тээвэрлэх горим зөрчигдөх	Зайлшгүй болох				
		Магад болох				
		Болзошгүй		+		

		Магад болохгүй				
		Болохгүй				
3.	Химийн бодисын сав баглаа боодлын хаягдал зайлуулалт	Зайлшгүй болох				
		Магад болох				
		Болзошгүй			+	
		Магад болохгүй				
		Болохгүй				
4.	Химийн бодис алдагдах	Зайлшгүй болох				
		Магад болох				
		Болзошгүй		+		
		Магад болохгүй				
		Болохгүй				
		Үл мэдэгдэх эрсдэл				
		Тэсвэрлэж болох эрсдэл				
		Шаардлагатай тохиолдолд бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх эрсдэл				
		Бууруулах арга хэмжээ зайлшгүй шаардлагатай эрсдэл				

Дээрхи хүснэгтээс хархад төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй 4 сөрөг тохиолдол байна. Үүнээс:

- Дунд эрсдэлтэй, тохиолдож болзошгүй 3 тохиолдол
- Их эрсдэлтэй, тохиолдож болзошгүй 1 тохиолдол тус тус тохиолдох магадлалтай байна.

Нийт эрсдэл нь тохиолдол багатай хэрэв эрсдэл учирсан тохиолдолд байгаль орчинд үзүүлэх эрсдлийн хэмжээ нь дунд зэрэг байна. Болзошгүй эрсдэл гарсан тохиолдолд бууруулах арга хэмжээг удирдлагын зүгээс цаг алдалгүй яаралтай авах шаардлагатай ба дүүргийн мэргэжлийн хяналт болон онцгой байдлын албанд мэдэгдэх хэрэгтэй.

3.1. Төслийн нийт нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэжлэх хугацаа

“Одон кашмер” ХХК-ний “Химийн бодис импортлох, хадгалах, худалдаалах” төслийн үйл ажиллагаанаас тухайн орчны байгаль орчны төлөв байдал, нийгэм-эдийн засаг, хүн амын амьдрах орчин, ажиллагсдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөлөл, тэдгээр нөлөөллийн хэлбэр, үргэжлэх хугацаа, эрчимшил зэргийг тогтооход магадлан жагсаах аргыг ашиглав.

Хүснэгт 5. Төслийн нийт нөлөөллийн хэлбэр, эрчим, үргэжлэх хугацаа

Нөлөөлөл БО-ны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	Богино хугацаанд	Дунд хугацаанд	Урт хугацаанд	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Нөлөөллийн хэлбэр			
								Сулавгар	Бага	Дунд	Хүчтэй
1. Байгаль орчин, экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх усны нөөц, горимын өөрчлөлт		x			x			x			
Гадаргын усны нөөц, горимын өөрчлөлт		x			x			x			
Ургамлан нөмрөгийн бүлгэмдлийн өөрчлөлт	x			x					x		
Хөрсөн бүрхэвчийн бүтэц, шинж чанарын өөрчлөлт	x				x				x		
Мэрэгч амьтдын амьдрах орчны аюул		x			x				x		
Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх		x			x			x			
2. Байгалийн нөөцийн ашиглалт											
Ахуйн зориулалтаар ашиглах усны нөөц		x			x			x			
Эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх /ахуйн хэрэгцээнд/		x			x			x			
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
Газрын доорх усны чанарын өөрчлөлт		x		x				x			
Гадаргын усны чанарын өөрчлөлт		x			x			x			
Агаарын бохирдол		x			x				x		
Хөрсний бохирдол	x		x							x	
Ургамлан нөмрөгийн бохирдол	x			x						x	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор											
Байгалийн унаган төрх өөрчлөгдөх					x						
Ландшафтын хэлбэр, дүрс, өнгө төрх өөрчлөгдөх		x									
Түүх, соёлын дурсгалт зүйлст нөлөөлөх								x			
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх								x			
5. Эдийн засаг нийгмийн асуудал											
Шинээр ажлын байр нэмэгдэх	+			+				+			
Тухайн орчинд оршин суугаа хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x			x			x			
Ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x				x			
Улсын төсвийн орлого нэмэгдэх	+			+				+			
ДҮН:	4	12	1	4	11	0	0	11	4	2	0
Дүгнэлт: Төслийн нөлөөллийг тогтооход нийт 22 асуудлыг багцлан авч үзсэн. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг болох ургамлан нөмрөгийн бүлгэмдэл, ургалт доройтох, хөрсөн бүрхэвчийн элэгдэл, эвдрэл, ахуйн бохир усны дооног, бие засах газар, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, ялаа батгана, шавж үржих, хүчтэй салхи шуурга, үер, гал түймэр, газар хөдлөлт, аянга зэрэг байгалийн гамшгаас үүдэн гарах аюул, осол зэрэгт шууд нөлөөлөл үзүүлэхээр байна. Шууд бус болон урт хугацаанд нөлөөлөлд ихэвчлэн гадаргын болон газрын доорх ус, түүний нөөцийн багасалт, бохирдол болон ажиллагсад, орчны хүн амын бодист нэрвэгдэх байдал зэрэг орж байна.											

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Одон кашмер” ХХК-ний “Химийн бодис ашиглах, хадгалах, импортлох” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулсан болно.

Ерөнхий зүйл. Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн (цаашид төсөл хэрэгжүүлэгч гэх) байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газарт хүргүүлэн хянуулж, батлуулна. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж, баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- ✓ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ)
- ✓ Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа орчны болон ажлын байрны нөхцлийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах эрх зүйн баримт бичиг болон шаардлагыг нь зайлшгүй хангаж мөрдөх стандартуудыг БОМТ-нд тодорхой тусгаж өгнө. Тухайн жилийн БОМТ боловсруулах, биелэлтийг тайлагнах журамд зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах агуулгатай байх бөгөөд хийх ажлын зардлыг тус бүрчлэн тооцож төлөвлөнө. Үүнд:

- ✓ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан төлөвлөгөө
- ✓ Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө
- ✓ Төслийн талбай орчмын түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

- ✓ Үйл ажиллагааны үеийн осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
- ✓ Үйл ажиллагааны үеийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- ✓ Тухайн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөлт
- ✓ БОМТ-г нөлөөллийн бүсийн олон нийт, оршин суугчдад тайлагнах, хэлэлцүүлэх арга хэмжээний төлөвлөлт зэргээс бүрдэнэ.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар								
1.	Агаарт химийн бодис тархах	Химийн бодисын агуулахын дотоод агааржуулалтын системийн ажиллагаанд байнга хяналт тавих	Агуулахын дотоод орчин	мг/м ³	350.0	-	350.0	MNS 4990:2023 Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4585:2025 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ.
				Дотоод төлөвлөлтөөр				
2.	Агаарын бохирдол тоосжилт үүсэх	Төслийн явцад ашиглах техник, машин механизмын янданд хорт хийг бууруулах зорилгоор авто машинуудыг үзлэг оншилгоонд тогтмол оруулж байх	Төсөлд ашигладаг тээврийн хэрэгсэл	-	200.0	-	200.0	
Хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар								
3.	Ахуйн болон хатуу хог хаягдлаар хөрс бохирдох	Бүх төрлийн хатуу болон ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал түр хадгалах саванд байнга хяналт тавих	Хог хаягдлын цэг, түүний орчинд	Дотоод төлөвлөлтөөр				Хог хаягдлын тухай хууль /2017 он/, Хөрс цөлжилтөөс хамгаалах тухай хууль

“Одон кашмер” ХХК

4.	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын горим, зөрчигдөж болгоомжгүй байдлаас химийн бодис алдагдсан тохиолдолд хөрс бохирдож болзошгүй	Химийн бодис урвалжийг алдагдахаас сэргийлж байнга анхаарал сэрэмжтэй ажиллах	Химийн бодисын агуулах түүний орчинд	Гэрээний дагуу	150.0	-	150.0	MNS 5850:2019 “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
5.	Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биетэнд дам нөлөөлөл үзүүлэх	Химийн бодис тээвэрлэх, зөөх үеийн аюулгүй байдлыг дүрмийг сахих		-	-	-	-	
Нийт					-	-	700.0	-

4.2. Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-д эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тарих, мөн Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд “Одон кашмер” ХХК нь Газрын тухай хууль болон Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум үндэсний хөдөлгөөний хүрээнд болон нэгж талбарын орчны тохижилт, цэцэрлэгүүлэлтийн төлөвлөгөөний дагуу НБОГ-аас зохион байгуулах зааж өгсөн талбайд мод тарих үйл ажиллагаанд оролцохоор төлөвлөсөн.

Хүснэгт 7.

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт ргачлал
Газрын тухай хууль болон Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум үндэсний хөдөлгөөний хүрээнд болон нэгж талбарын орчны тохижилт, цэцэрлэгүүлэлтийн төлөвлөгөөний дагуу НБОГ-аас зохион байгуулах зааж өгсөн талбайд мод тарих үйл ажиллагаанд оролцох	Цаг тухайд нь оролцох, Хавар, Намрын улиралд	Төслийн талбайд	800.0	2026 он	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт MNS 5916:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2023
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний нийт зардал			800.0	-	-

4.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртсөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлын тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргадаг ба уг төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг хийх шаардлагагүй болно.

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Тухайн төслийн үйлчилгээ болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд зайлшгүй нүүлгэх шаардлагатай иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй болно.

4.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд түүх, соёлын өв дурсгалууд илрээгүй болно.

4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Авилаа осол эрсдлээс хамгаалах ажил нь химийн бодисын лабораториудын үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой юм. Доорхи хүснэгтэд төслийн үйл ажиллагааны явцад гарч болзошгүй осол, эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх ажлын хүрээ, давтамж, баримтлах стандарт зэргийг тусган оруулав. /Шаардагдах хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч нь санхүүгийн төлөвлөгөөндөө тусгасан байх шаардлагатай/.

Хүснэгт 8. Осол эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах стандарт, аргачлал
Цахилгаан хэрэгслийн гэмтэл, хэт халалт зэргээс үүдэн гал түймэр гарах	Галын аюулын үед ашиглах багаж хэрэгслийг бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Химийн бодисын хадгалах агуулахад	Дотоод төлөвлөлтөөр	Төслийн үйл ажиллагааны явцад байнга хяналт тавих	Гамшгаас хамгаалах тухай: Зүйл 27-1 Галын аюулгүй байдлын тухай: Зүйл 16-1, 2; Зүйл 18-1, 2
Химийн бодис алдагдсанаас ажиллагсадын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Ажиллагсад эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх	Химийн бодисын хадгалах агуулахад		Үйл ажиллагааны туршид	MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
	Анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангасан байх				
	Химийн бодистой харьцах үеийн зориулалтын хувцастай байх /гутал, резинэн бээлий, хамгаалалтын хошуувч/				
	Сургалт, туршилт ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах				

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний арга хэмжээний зардал

Төслийн үйл ажиллагааны үед ажилчдын ахуйн хог хаягдал, химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдал гарна. Төслийн үйл ажиллагааны үед гарсан хог хаягдлыг байгаль орчинд бохирдол багатайгаар зайлуулах, ангилан ялгах дахин ашиглах асуудлыг зохицуулахад менежментийн төлөвлөгөөний зорилго оршино. Ахуйн лонх, лааз, цаас, хоолны үлдэгдэл, бусад гэсэн байдлаар нь ангилан хадгалж дахин ашиглагдах хэсгийг нь хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлэн, үлдэх буюу ашиглагдахгүй хэсгийг хогийн цэгт зайлуулах нь зүйтэй. Аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгуулагад хүлээлгэн өгч мэргэжлийн түвшинд устгуулах шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэгч нь БОАЖСайлын А/21 тушаалын Хавсралт 3. Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайлангийн маягт, Хавсралт 5. Аюултай хог хаягдал цуглуулах үйл ажиллагаа эрхлэгчийн тайлангийн маягтын дагуу тус тус бүртгэлийг хөтөлж ажиллана.

Хүснэгт 9.

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлын цэг, хог хаягдал ангилан ялгах талбай, төслийн орчинд бохирдол үүсгэж болзошгүй	Хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх	Улирал бүр	250.0	Хог хаягдлын тухай хууль
	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Тухай бүрт нь	-	
	Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулж байх	Тогтмол	-	MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
	Химийн хог хаягдал, химийн бодисын сав, баглаа боодлыг аюултай хог хаягдал зайлуулах гэрээний дагуу зохицуулах	-	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр	ЗГ-н 2018 оны 116 тоот Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, бүртгэх тайлагнах журам
Нийт зардал /мян.төг/			250.0	-

4.8. БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр БОМТ -ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь нутаг дэвсгэрийн дүүрэг, хороо иргэдийн нийтийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

Хүснэгт 10. БОМТ болон түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Хариуцах эзэн
1.	Төрийн захиргааны төв байгууллага /БОУАӨЯ/	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тайлагнах, батлуулах	Төсөл хэрэгжүүлэгч
2.	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хорооны иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулаж танилцуулах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулаж санал авах	Төсөл хэрэгжүүлэгч
3.	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн бүх шатны засаг дарга	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж тайланг хүргүүлэх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулаж санал авах	Төсөл хэрэгжүүлэгч

4.10. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хүснэгт 12.

№	Хийгдэх ажлын нэр төрөл	Хийгдэх шаардлага	Хийх хугацаа	Ажлын хэмжээ	Шаардагдах хөрөнгө
1.	Байгаль орчныг хамгаалах асуудлаар жил бүрийн тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цаг тухайд нь гаргаж өгөх	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу	Жил бүр	Жил бүр БОМТ төлөвлөгөөг боловсруулж батлуулах	-

“Одон кашмер” ХХК

2.	Хог хаягдлын талаар боловсрол олгох сургалтыг мэргэжлийн хүмүүсээр зохион байгуулах	Хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгуулагаас сургалт авах	Жил бүр	Сургалт зохион байгуулах	Дотоод зардлаар
3.	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлж байх	-	Үйл ажиллагааны явцад тогтоосон хугацаанд		Гэрээний дагуу

4.11. Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

“Одон кашмер” ХХК-ийн “Химийн бодис импортлох, хадгалах, худалдаалах” төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, байгаль орчны доройтол, гэнэтийн бохирдлыг хянах, бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор байгаль орчны мониторингийн үйл ажиллагааг явуулна. Мониторинг нь байнгын ажиглалт шинжилгээгээр гарсан үзүүлэлтүүдийн хяналт тэдгээрийн үнэлгээ болон хэтийн төлөв байдлыг урьдчилан таамаглах зэрэг үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагааг хяналт, төлөвлөгөөтэй, цэгц явуулахын тулд “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” (ОХШХ)-ийг боловсруулан мөрдөнө.

Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	2026 оны зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
1.	Агаарын чанар	Агуулахын хашаан дотор	Жилд 2 удаа	Агаарын ерөнхий чанарын үзүүлэлт	75,0	150.0	МУ-н стандартууд, MNS 4585:2025 “Агаарын чанар”, MNS 4585:1998 “Агаар орчны чанарынүзүүлэлт”; MNS 0017-2-3-16:1988 “Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам” Дээжлэхдээ MNS 4585-98 MNS 4048:1988 баримтлах Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885 : 2008
		Агуулах дотор			75.0		
2.	Хөрс: ялзмаг, рН, механик бүрэлдэхүүн. азот, фосфор, кали, давсжилт, хүнд металлууд, 1 см3 дэхь бактери, эмгэг төрүүлэгч бичил биетэн байгаа эсэх	Агуулахын хашаан дотор	Жилд 2 удаа	Агрохимийн үзүүлэлт, хүнд металл	25.0 40.0	100.0 160.0	MNS 5850 : 2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
Нийт						410.0	-

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд нийт 2160.0 мян.төг зарцуулахаар төлөвлөсөн.

Хууль зүйн сайдын 2016 оны
А 204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000213744

<u>2009.07.31</u> <i>/ Бүртгэсэн он, сар, өдөр /</i>	<u>9019048061</u> <i>/ Хувийн хэргийн дугаар /</i>	<u>5318246</u> <i>/ Регистрийн дугаар /</i>
Одон кашмер <i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>		
Дүрэм <i>/ Үүсэн байгуулах баримт бичиг /</i>		
<u>Тушаал</u> <i>/ шийдвэрийн нэр /</i>	<u>A-2817</u> <i>/ дугаар /</i>	<u>2009.07.30</u> <i>/ он, сар, өдөр /</i>
<u>4610</u> <i>/ Код /</i>	Гадаад худалдаа	
<u>4620</u> <i>/ Код /</i>	Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа	
	<i>/ Үйл ажиллагааны чиглэл /</i>	
<u>19.07.30-21.07.30</u> <i>/ хугацаа /</i>	<u>1</u> <i>/ гишүүдийн тоо /</i>	<u>266,900.00</u> <i>/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /</i>
Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Академич Содномын 54-1, Утас1: 80207768, Утас2: , Факс: <i>/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /</i>		
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР <i>/ Бүртгэсэн байгууллагын нэр /</i>		
УЛСЫН БҮРТГЭГЧ <u>Э.ЭРДЭНБИЛЭГ</u> <i>/гэмдэг/</i> <i>/Гарын тэмдэг/</i>		
Гэрчилгээ дахин олгосон <u>2020 он 10 сар 22 өдөр</u>		



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	овоотой Seyinjituge-г Захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2019.05.17	Д.Чулуунтуяа
2	Дахин гэрчилээг олгов.	2020.10.22	Э.Эрдэнэбилэг
3	Үйл ажиллагаа эрхлэх хугацааг хугацаагүй болгов.	2021.07.22	Э.Эрдэнэбилэг



ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ,
ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ,
АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2023-04-21

Дугаар: 0002412

Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: ОДОН КАШМЕР ГХО-тай ХХК

Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9019048061

Регистрийн дугаар: 5318246

Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Академич Содномын 54-1

Утас: 80207768

Дараах химийн хортой, аюултай бодис:

Импортолох, ашиглах, худалдах

аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай

зөвшөөрлийг

2023.04.21-2028.04.21

хүртэл хугацаагаар олгов.

№	Бодисын нэр		Томьёо	Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/	Ангилал	Үйлдвэрлэсэн улс	Хэмжээ
	Монгол	Олон улсын					
1	Саван	Cocoamido-propyl betian	$C_{19}H_{38}N_2O_8$ NaCl, H ₂ O	61789-40-0			2.5 тн
2	Зөөлрүүлэгч бодис	Poly(dimethyl siloxane/	$[C_2H_6OSi]_n$	63148-62-9			2.5 тн
3							
4							
5							
6							
7							
8							

Улсын хилээр нэвтрүүлэх боомт:

Сүхбаатар, Алтанбулаг, Замын Үүд, Бичигт,
Баянхошуу, Гашуунсухайт, Чингис хаан

Зөвшөөрөл олгосон: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Төрийн нарийн бичгийн дарга /ын албан үүргийг түр

орлон гүйцэтгэгч

С.ЦОГТГЭРЭЛ /

Химийн хорт болон аюултай бодисын бодлого
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Ц.БАТЖАРГАЛ /